



Аудитын код: САГ-2018/23/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 260512 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан

Аудитор Ж.Болормаа

Утас: 261628 Цахим хаяг: javkhlant@audit.gov.mn
bolormaaj@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан	3
2	Аудитын гэрчилгээ.....	4
3	Аудитын тайлан.....	1
3.1	Оршил.....	1
3.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	1
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
3.5	Дотоод аудит	3
3.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	4
3.7	Шилэн дансны мэдээлэл	5
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
3.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
3.9.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдааны талаар	5
3.9.2	Салбарын хөрөнгө оруулалтын тайлангийн талаар.....	6
3.9.3	Төслийн гэрээт ажлын гүйцэтгэл, сонгон шалгаруулалтын талаар.....	7
3.9.4	Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар.....	7
3.9.5	Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагуудын талаар	7
3.10	АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	8
3.11	ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД.....	9
3.12	АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	9
3.13	ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	9
3.14	МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР	9
3.15	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ	10
3.16	Үр өгөөжийн тооцоолол	10
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	11
4.1	Төслийн гэрээт ажлын гүйцэтгэл, сонгон шалгаруулалтын талаар.....	12
4.2	Шилжүүлсэн хөрөнгийн бүртгэлийн талаар	12
4.3	Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн талаар	13
4.4	Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар.....	13
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	14
5.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	14
5.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
	Аудитын явцад тогтоосон акт, албан шаардлагын жагсаалт.....	21

Албан шаардлага.....

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
23
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА

2018.04.25 № 1046

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна. Иймд хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын байдлаа санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын гол асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийн шинж чанар болон мөнгөн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшинөөс давсан нь "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн эргэн төлөлтийн авлага нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх",
- Хөдөлмөрийн салбарт төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн 1,717.5 сая төгрөгийн санхүүжилттэй 25 төсөл хангалтгүй үнэлэгдсэн ба урьдчилгаа 1,178.7 сая төгрөгийг зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх",
- Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл хангалтгүй, хугацаа 2-3 жилээр сунгагдаж төсөвт өртөг 1.1 - 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",
- Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй төсөл, хөтөлбөр сонгон шалгаруулж, санхүүжилт олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж заасантай тус тус нийцэхгүй, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомжид нийцэж байх гэсэн Үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 05-наас 04 дүгээр сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхалан, аудитор Ж.Болормаа нар гүйцэтгэв.



Төсвийн ерөнхийлөн захирагч 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/989 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэм зорилго нь хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад орших бөгөөд дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаар дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8 хөтөлбөрийн хүрсэн үр дүнгийн талаархи чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлт 84.7 хувьтай байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөрийн биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн 3 үзүүлэлтийн биелэлт 100 хувь,
- Нийгмийн даатгалын 5 үзүүлэлтийн биелэлт 80 хувь,
- Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн 6 үзүүлэлтийн биелэлт 92.5 хувь,
- Мэргэжлийн боловсрол, сургалтын 3 үзүүлэлтийн биелэлт 70 хувь,
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөрийн 2 үзүүлэлтийн биелэлт 35 хувь,
- Хөдөлмөрийн салбарын судалгааны 1 үзүүлэлтийн биелэлт 100 хувь,
- Салбарын үйл ажиллагааны хэрэгжилтээр үнэлэгдэх нийгмийн хамгааллын бодлого, удирдлагын 3 үзүүлэлтийн биелэлт 100 хувь байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.



2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 28 горим, сорил гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/270 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд яамны харьяа байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, тайлагналын онцлогийг тусгасан байна.

Санхүүгийн ажил гүйлгээг бүртгэх, хянах, боловсруулах, тайлан гаргах үйл ажиллагааг санхүүгийн “Axplorer” програмаар, тайлангийн нэгтгэлийг Сангийн яамны “Э-тайлан”-гийн програмаар нэгтгэсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцаж түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

2.5 Дотоод аудит

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод аудитыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 2017/01 дугаарт тогтоолоор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны төлөвлөгөөг баталсан байна.

Төлөвлөгөөнд 11 байгууллагад дотоод аудит хийхээр төлөвлөсөн бөгөөд аудитын ажлын хамрах хүрээ, хариуцах эзэн, хугацааг тодорхой тусгасан байна. Хүснэгт 1. Дотоод аудитын ажлын үзүүлэлт



**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	11	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	12	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	8	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	149
		Дүн (сая.төг)	3,673.9
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	264
		Дүн (сая.төг)	2,559.6
6	Тогтоосон төлбөрийн акт,	Тоо	16
		Дүн (сая.төг)	334.9
7	Өгсөн албан шаардлагын	Тоо	9
		Дүн (сая.төг)	779.4

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны дотоод аудит, хяналт-шалгалтын тайлан

Дотоод аудит, хяналт-шалгалтаар илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байх, цаашид төсвийн орлогын бүрдүүлэлт болон хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хариуцлага хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 89 хувь, акт, албан шаардлагын хэрэгжилт 51.6 хувь байна.

Мөн дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтийг хянаж ажилласан бөгөөд хэрэгжилт 80.3 хувьтай байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйл ангиар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төвлөрүүлэх орлогын хэмжээг 77,664.1 сая төгрөг, төсөв зарцуулах эрхийг 1,146,885.2 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,146,885.2	1,115,549.3	(31,335.9)
Урсгал зардал	1,103,451.9	1,079,464.1	(23,987.7)
Бараа, ажил үйлчилгээний зардал	96,741.8	96,314.6	(427.2)
Татаас	570,729.4	570,729.4	-
Урсгал шилжүүлэг	435,980.6	412,420.1	(23,560.5)
Хөрөнгийн зардал	23,433.2	16,085.1	(7,348.1)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	20,000.0	20,000.0	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,146,885.2	1,112,256.4	(34,628.8)
Улсын төсвөөс санхүүжих	1,060,445.0	1,042,372.3	(18,072.7)
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	527.2	506.8	(20.4)
Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,458.0	55,238.4	(10,219.6)
Гадаадын зээлийн эх үүсвэрээс санхүүжих	9,376.0	7,019.3	(2,356.7)

Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	11,078.9	7,119.5	(3,959.4)
-----------------------------------	----------	---------	-----------

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төвлөрүүлэх орлогын хэмжээг 600.0 сая төгрөгөөр баталсны дагуу Улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Улсын төсвөөс санхүүжих эх үүсвэр 18,072.7 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн нь 12,370.4 сая төгрөгийг татан төвлөрүүлж, улсын төсвөөс 5,702.3 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Бараа үйлчилгээний зардал нь нийт дүнгээр батлагдсан төсвөөс хэтрээгүй боловч Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал батлагдсан төсвөөс 2,104.5 сая төгрөгөөр хэтэрсэн нь Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төслийн 1,674.6 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төслийн 1,005.4 сая төгрөгийн зардал нь төсөв хэтрэхэд нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үлдэгдэл тэнцлийг өмнөх онтой харьцуулахад авлага 12,721.1 сая төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр 1,801.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлага 12,318.1 сая төгрөгөөр, жижиг зээлийн авлага 2,993.9 сая төгрөгөөр өсч, Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төслийн гадаад эх үүсвэрийн санхүүжилт 1,805.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 6,252.1 сая төгрөгийн хүүхэд хамгаалал, хөгжлийн үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг хийсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn веб сайтад төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад гэсэн 3 төрлийн мэдээллийг оруулсан байна.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тайлант оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж “тогтсон хугацаа”-нд мэдээлэл байршуулсан байдал 89.1 хувьтай байна гэж үнэлсэн байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар


Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 24 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн 5 дансанд 28 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, тартасан шийдэл

2.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдааны талаар



Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулахад татварын бус орлого болон тусламж санхүүжилтийн орлогын хооронд 945.3 сая төгрөгийн орлогыг гүйлгэн бүртгэсэн,

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант оны дахин илэрхийлсэн үлдэгдэл 1.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан,

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татварын бус орлогын тодруулга 36.9 сая төгрөг, үйл ажиллагааны зардлын тодруулга 6.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дээрх алдааны 45.3 сая төгрөгийн залруулга хийгдэв.

2.9.2 Салбарын хөрөнгө оруулалтын тайлангийн талаар

- Хөрөнгө оруулалтын тайланд 7,840.2 сая төгрөгийн барьж дуусаагүй барилга байгууламжийг дуусаагүй барилга дансанд тайлагнасан нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 6.1-д “... барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, ... захиалагч байгууллага эргэлтийн хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулж бүртгэв.


- Салбарын хөрөнгө оруулалтын тайланд түүврээр аудит хийхэд Дорнод аймгийн Хэрлэн сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр барьж ашиглалтанд оруулах ажлын гэрээнүүд 2014 онд 6 сарын хугацаатай хийгдсэн боловч гэрээний хугацаа 2 - 3 жилээр сунгагдаж төсөвт өртөг 1.1 - 1.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 3,373.8 сая төгрөгийн өртөгтэй дотуур байрыг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор хүлээлгэж өгөхөөр гэрээг сунгасан боловч улсын комисс хүлээж аваагүй байгаа нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.4-д “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, ... тайлагнах” гэж заасныг баримталж ажиллах зөвлөмж өгөв.

- Хөрөнгө оруулалтын тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 3,499.7 сая төгрөгийн цахим мэдээллийн төвийн барилга нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн тайланд давхар бүртгэлтэй байсныг тайлант онд залруулсан боловч 3,134.9 сая төгрөгөөр буюу 364.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө 26-д “Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг анхны удаа өртгөөр нь хэмжинэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилгыг хөрөнгө оруулалт хийсэн өртгөөр залруулж бүртгэх зөвлөмж өгөв.



2.9.3 Төслийн гэрээт ажлын гүйцэтгэл, сонгон шалгаруулалтын талаар

- Хөдөлмөрийн яамнаас 2016 онд төрийн бус байгууллагуудтай хөдөлмөрийн салбарт гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн 3,719.5 сая төгрөгийн санхүүжилттэй 46 төслийн гэрээт ажлын гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлангаар 1,717.5 сая төгрөгийн санхүүжилттэй 25 төсөл хангалтгүй үнэлгээ авсан ба төслийн болон санхүүгийн тайлангаа ирүүлээгүй 5 төсөл байна.

Дээрх гэрээт ажлын урьдчилгаа 1,178.7 сая төгрөгийг тайлант онд зардлын дансанд бүртгэсэн байна.

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Үүний дагуу төслийн сонгон шалгаруулалтаар шалгарсан нийт 3,986.0 сая төгрөгийн санхүүжилттэй 29 төслөөс аудитын түүвэрт хамрагдсан 650.0 сая төгрөгийн санхүүжилттэй 4 төсөл нь хөтөлбөр, төслийн тэргүүлэх чиглэлд хамааралгүй, ерөнхий шаардлагад нийцэхгүй, шалгуур үзүүлэлт хангахгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ... үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2.9.4 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 98 байгууллагын тайлан нэгтгэгдсэнээс 10 тайлан Хязгаарлалттай, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 5 төсөл, жижиг дунд үйлдвэрийг дэмжих 5 төвийн тайлан аудит хийгдээгүй нэгтгэгдсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,927.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 146.2 сая төгрөгийн 17 төлбөрийн акт, 1,520.6 сая төгрөгийн 30 албан шаардлага, 3,261.0 сая төгрөгийн 184 зөвлөмж өгөгдсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсны дагуу дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгөв.

2.9.5 Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагуудын талаар

Дараах байгууллагууд Хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
- Ахмад настны асрамжийн үндэсний төв
- Дорнод аймаг дахь Политехник коллеж
- Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
- Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
- Ховд аймаг дахь "Хөгжил" Политехник коллеж
- Хөвсгөл аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
- Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж
- Монгол Солонгосын Политехник коллеж



- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “ ... санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, ... санал, дүгнэлт авсан, ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах ...” гэж заасны дагуу зохих арга хэмжээ авах албан шаардлага өгөв.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар анхаарал татахуйц дараах асуудал байна.

1. Ажлын байрны төлбөрийн орлогын талаар

- Засгийн газрын 2016 оны 201, 2017 оны 99, 145 дугаар тогтоолуудаар нийт 13 аж ахуйн нэгж, байгууллагын 4567 гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлснөөр 7,899.7 сая төгрөгийн, Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.1.3-д “боловсролын байгууллага, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын зөвлөх мэргэжилтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтанг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө” гэж заасны дагуу 1294 гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлж 4,640.3 сая төгрөг нийт 12,540.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрөх боломжийг алдсан байна.

2. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэлийн талаар


- Азийн хөгжлийн банкны 23.8 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр хэрэгжиж буй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” 2015 оноос 4 жилийн хугацаатай хэрэгжихээр гэрээтэй боловч тайлант оны байдлаар 1.7 сая ам.долларын гүйцэтгэлтэй байгаа нь нийт санхүүжилтийн 7 хувь байна.
- Азийн хөгжлийн банкны 23.0 сая ам.долларын хөнгөлттэй зээлээр хэрэгжиж буй “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл” нь 2017 оны 5 сарын 31-нд дуусах гэрээтэй боловч төслийн гүйцэтгэл 38 хувьтай бөгөөд хугацааг 3 жилээр сунгах хүсэлт гаргасан байна.
- “Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх” 1.5 сая ам.долларын санхүүжилттэй, техник туслалцааны төсөл нь 2017 оны 10 дугаар сард хэрэгжиж дууссан боловч 2.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Ажил эрхлэлтийг дэмжих сангийн төсөв 323.8 сая төгрөгөөр батлагдсан боловч тайлант онд үйл ажиллагаа эхлээгүй байна.
- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдаж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн барилгын ажлын гүйцэтгэгчийн ирүүлсэн тайлангаар нийт 26,178.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж гүйцэтгэл нь 55 хувьтай байна.

3. Тайлант онд бүртгэсэн барилгын талаар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн А-5/919 дугаартай албан бичигт заасны дагуу 2,000.0 сая төгрөгийн өртөг бүхий Хөдөлмөрийн нөхцлийн лабораторийн барилгыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Тус барилга нь 570.61 м² бүхий 5 давхар байшин бөгөөд орон сууцны хорооллын байртай үргэлж баригдсан барилга байна.

Дээрх барилгыг Визардконстракшн ХХК-иас 2016 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн №2016/126 дугаартай Худалдах, худалдан авах гэрээгээр шилжүүлж авсан байна.



2.11 ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэрэгт үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллагуудын 2018 оны завсрын аудитаар дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах,
- Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан Төслийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.4-д заасны дагуу төслийн явцын тайланг авч олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 18,920.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 7,886.3 сая төгрөгийн алдааг залруулж, 146.2 сая төгрөгийн 17 акт, 1,520.6 сая төгрөгийн 31 албан шаардлага, 9,367.1 сая төгрөгийн 188 зөвлөмж өгөгдсөн байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагыг тооцоо нийлж, баталгаажуулах талаар, худалдан авах ажиллагааны талаар, анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар, орон тооны талаар, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах талаар өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт 81 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 22,355.2 сая төгрөгийн авлага, 532.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байсныг аудитын явцад дахин хянахад авлагын 21,622.1 сая төгрөг, өр төлбөрийн 521.4 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,200.6 сая төгрөгийн ажил гүйлгээг данс бүртгэлд бүртгэсэн зөрчлийг арилгах ажлын хүрээнд 1,722.8 сая төгрөгийн анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлсэн байна.


Зөвлөмжийн хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 3/2339 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитын төлөвлөх ба гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон болно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцож санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 11,065.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг төлөвлөснөөс өөрчлөөгүй боловч тайлант онд орлого, зарлага өмнөх оноос өссөн тул хувийг 1 хувь болгон багасгаж хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл холбогдох заавар журмтай нийцэж байгааг тулган шалгах нэмэлт горим, сорил хэрэгжүүлэв.



2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийн шинж чанар болон мөнгөн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшинөөс давсан нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлага нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”,
- Хөдөлмөрийн салбарт төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн 1,717.5 сая төгрөгийн санхүүжилттэй 25 төсөл хангалтгүй үнэлэгдсэн ба урьдчилгаа 1,178.7 сая төгрөгийг зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”,
- Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл хангалтгүй, хугацаа 2 - 3 жилээр сунгагдаж төсөвт өртөг 1.1 - 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,
- Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй төсөл, хөтөлбөр сонгон шалгаруулж, санхүүжилт олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасантай тус тус нийцэхгүй, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомжид нийцэж байх гэсэн Үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2.16 Үр өгөөжийн тооцоолол

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 364.8 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим чиглэгдсэн.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан асуудал цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар нэгтгэн харуулав.

Дараах зөвлөмжүүдийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.



**3.1 Төслийн гэрээт ажлын гүйцэтгэл,
сонгон шалгаруулалтын талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөдөлмөрийн салбарт төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн 1,717.5 сая төгрөгийн санхүүжилттэй 25 төслийн гүйцэтгэл хангалтгүй, төслийн болон санхүүгийн тайлангаа ирүүлээгүй 5 төсөл байна.

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй төслүүд сонгон шалгаруулж, санхүүжилт олгосон байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу хийгдэхгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ... үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

**3.2 Шилжүүлсэн хөрөнгийн бүртгэлийн
талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөрөнгө оруулалтын тайлангийн дуусаагүй барилга данснаас хассан 3,499.7 сая төгрөгийн цахим мэдээллийн төвийн барилга нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн тайланд 3,134.9 сая төгрөгөөр буюу 364.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Эрсдэлүүд

Төрийн өмч бодитоор үнэлэгдэхгүй байх, нягтлан бодох бүртгэл стандартад нийцэхгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө 26-д “Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг анхны удаа өртгөөр нь хэмжинэ” гэж заасны дагуу хөрөнгө оруулсан өртгөөр залруулж бүртгэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.3 Хөрөнгө оруулалтын ажлын
гүйцэтгэлийн талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Дорнод аймгийн Хэрлэн сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр, Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр барьж ашиглалтанд оруулах ажлуудын гэрээ 2014 онд 6 сарын хугацаатай хийгдсэн боловч гэрээний хугацаа 2 - 3 жилээр сунгагдаж төсөвт өртөг 1.1 - 1.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 3,373.8 сая төгрөгийн өртөгтэй дотуур байрыг 2017 оны 12 дугаар сарын 1-ны дотор хүлээлгэж өгөхөөр гэрээг сунгасан боловч улсын комисс хүлээж аваагүй байна.

Эрсдэлүүд

Хөрөнгө оруулалтыг бодитой төсөвлөхгүй байх, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, ... тайлагнах” гэж заасныг баримталж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

**3.4 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТААР
ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 98 байгууллагын тайлан нэгтгэгдсэнээс 10 тайлан Хязгаарлалттай, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 5 төсөл, жижиг дунд үйлдвэрийг дэмжих 5 төвийн тайлан аудит хийгдээгүй нэгтгэгдсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,927.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 146.2 сая төгрөгийн 17 төлбөрийн акт, 1,520.6 сая төгрөгийн 30 албан шаардлага, 3,261.0 сая төгрөгийн 184 зөвлөмж өгөгдсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуульд заасан хариуцлагатай байх зарчим хэрэгжихгүй байх,

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-д “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсны дагуу дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,879,432.1	140,336,941.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,571,926.8	5,283,386.4
АВЛАГА	100,275,916.8	112,997,036.0
УРЬДЧИЛГАА	150,025.5	603,870.4
БАРАА МАТЕРИАЛ	12,881,563.1	13,612,445.2
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	7,840,203.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	204,117,220.3	194,801,236.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	204,117,220.3	194,801,236.0
Биет хөрөнгө	203,020,891.0	193,948,032.8
Биет бус хөрөнгө	1,096,329.3	853,203.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	323,996,652.4	335,138,177.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,201,460.0	7,331,330.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,409,824.6	1,738,225.7
Богино хугацаат зээлийн өглөг	1,170,542.6	33,795.9
Өглөг	5,160,195.0	1,611,149.4
Урьдчилж орсон орлого	79,087.0	93,280.4
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,791,635.4	5,593,105.0
Урт хугацаат зээл	3,791,635.4	5,593,105.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	313,795,192.4	327,806,846.4
Засгийн газрын хувь оролцоо	313,795,192.4	327,806,846.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	81,987,183.0	82,447,155.0
Хуримтлагдсан үр дүн	195,450,779.5	209,068,774.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36,357,229.9	36,290,917.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	323,996,652.4	335,138,177.1



4.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	796,504,188.6	1,126,716,860.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,392,255.1	66,098,801.8
Нийтлэг татварын бус орлого	121,392,255.1	58,979,296.7
Тусламжийн орлого	0.0	7,119,505.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	675,111,933.5	1,060,618,058.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	729,729,045.4	1,106,593,869.0
УРСГАЛ ЗАРДАЛ	704,397,162.0	1,100,139,113.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,222,279.9	121,391,435.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,151,637.5	47,865,736.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,186,743.0	5,245,571.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,975,379.6	10,723,821.6
Хангамж, бараа материалын зардал	2,011,850.5	5,097,060.8
Нормативт зардал	4,701,986.9	5,225,729.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,297,741.1	1,196,807.1
Томилолт, зочны зардал	462,452.4	1,019,047.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,248,396.8	14,816,143.6
Бараа үйлчилгээний бусад зардал	27,186,092.2	30,201,516.8
ТАТААС	494,879,039.0	570,240,339.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,295,843.2	408,507,338.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,331,883.4	6,454,755.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	66,775,143.1	20,122,991.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,188,211.6	246,349.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	930,571.9	7,710,775.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	68,032,782.8	12,658,565.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	245,865,822.2	0.0	245,865,822.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,865,822.2	0.0	245,865,822.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-103,412.6	0.0	-103,412.6
Тайлант үеийн үр дүн	68,032,782.8	0.0	68,032,782.8
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313,795,192.4	0.0	313,795,192.4
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	313,795,192.4	0.0	313,795,192.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,675,074.8	0.0	1,675,074.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	315,470,267.2	0.0	315,470,267.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-66,312.7	0.0	-66,312.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-255,673.6	0.0	-255,673.6
Тайлант үеийн үр дүн	12,658,565.5	0.0	12,658,565.5
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,806,846.4	0.0	327,806,846.4



4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	779,366,708.6	1,179,207,745.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,891,902.1	118,075,555.4
Нийтлэг татварын бус орлого	103,891,902.1	110,956,050.3
Тусламжийн орлого	0.0	7,119,505.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	675,474,806.5	1,061,132,189.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	736,369,854.1	1,144,020,655.7
УРСГАЛ ЗАРДАЛ	736,369,854.1	1,144,020,655.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,224,134.1	104,743,993.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,850,337.2	47,760,773.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,042,847.7	5,276,729.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,377,718.8	10,791,106.7
Хангамж, бараа материалын зардал	1,530,625.9	3,671,306.7
Нормативт зардал	4,875,452.6	5,558,693.5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,073,328.1	1,141,985.0
Томилолт, зочны зардал	484,190.7	1,007,938.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,359,889.1	14,197,611.7
Бараа үйлчилгээний бусад зардал	12,629,744.0	15,337,848.3
ТАТААС	494,879,039.0	570,240,339.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,266,681.0	469,036,323.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	42,996,854.5	35,187,089.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,424,927.7	16,536,946.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,424,927.7	16,536,946.5
Дотоод эх үүсвэрээр	36,424,927.7	16,536,946.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-36,424,927.7	-16,536,946.5
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-19,938,683.4
Бусад эх үүсвэр	0.0	97,563.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	20,000,000.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	36,247.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,571,926.8	-1,288,540.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	6,571,926.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,571,926.8	5,283,386.4



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,146,885,230,600.00	1,115,549,323,076.48	31,335,907,523.52	97.27
УРСГАЛ ЗАРДАЛ	1,103,451,944,400.00	1,079,464,182,666.02	23,987,761,733.98	97.83
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,741,877,300.00	96,314,633,725.81	427,243,574.19	99.56
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,809,478,800.00	45,523,014,852.89	286,463,947.11	99.37
Үндсэн цалин	36,269,777,500.00	36,768,413,363.88	-498,635,863.88	101.37
Нэмэгдэл	6,443,461,700.00	5,912,213,132.01	531,248,567.99	91.76
Унаа хоолны хөнгөлөлт	3,006,608,600.00	2,761,603,840.00	245,004,760.00	91.85
Гэрээт ажлын хөлс	89,631,000.00	80,784,517.00	8,846,483.00	90.13
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,109,667,900.00	5,034,150,065.09	75,517,834.91	98.52
Тэтгэврийн даатгал	3,330,309,500.00	3,261,639,218.74	68,670,281.26	97.94
Тэтгэмжийн даатгал	444,083,100.00	436,270,681.26	7,812,418.74	98.24
ҮОМШӨ-ний даатгал	356,628,200.00	364,803,608.08	-8,175,408.08	102.29
Ажилгүйдлийн даатгал	88,968,300.00	91,121,706.79	-2,153,406.79	102.42
Эрүүл мэндийн даатгал	889,678,800.00	880,314,850.22	9,363,949.78	98.95
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,400,890,500.00	10,063,406,401.40	337,484,098.60	96.76
Гэрэл, цахилгаан	1,418,963,400.00	1,432,508,057.76	-13,544,657.76	100.95
Түлш, халаалт	7,665,017,700.00	7,380,163,178.04	284,854,521.96	96.28
Цэвэр, бохир ус	831,815,800.00	752,913,469.14	78,902,330.86	90.51
Байрны түрээс	485,093,600.00	497,821,696.46	-12,728,096.46	102.62
Хангамж, бараа материалын зардал	1,734,228,200.00	1,571,642,772.33	162,585,427.67	90.62
Бичиг хэрэг	395,567,200.00	346,891,787.83	48,675,412.17	87.69
Тээвэр, шатахуун	493,860,500.00	447,967,342.76	45,893,157.24	90.71
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	468,227,000.00	384,180,248.94	84,046,751.06	82.05
Ном, хэвлэл	17,189,700.00	1,892,490.00	15,297,210.00	11.01
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,881,700.00	61,143,397.00	9,738,303.00	86.26
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	288,502,100.00	329,567,505.80	-41,065,405.80	114.23
Нормативт зардал	4,634,177,700.00	4,157,856,122.85	476,321,577.15	89.72
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	727,304,800.00	606,754,770.65	120,550,029.35	83.43
Хоол, хүнс	3,494,770,700.00	3,146,712,764.20	348,057,935.80	90.04
Нормын хувцас, зөөлөн эдлэл	412,102,200.00	404,388,588.00	7,713,612.00	98.13
Эд хогшил, урсгал засварын зардал	819,063,700.00	799,609,530.68	19,454,169.32	97.62
Багаж, техник, хэрэгсэл	192,334,600.00	162,467,867.50	29,866,732.50	84.47
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,484,700.00	24,729,020.00	1,755,680.00	93.37
Урсгал засвар	600,244,400.00	612,412,643.18	-12,168,243.18	102.03
Томилолт, зочны зардал	407,129,300.00	358,567,516.50	48,561,783.50	88.07
Дотоод албан томилолт	407,129,300.00	358,567,516.50	48,561,783.50	88.07
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,789,923,800.00	16,894,407,541.65	-2,104,483,741.65	114.23

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,089,405,500.00	16,303,022,853.51	-2,213,617,353.51	115.71
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	152,816,600.00	123,258,518.00	29,558,082.00	80.66
Даатгалын үйлчилгээ	119,696,700.00	114,082,651.02	5,614,048.98	95.31
Тээврийн хэрэгслийн татвар	42,001,500.00	33,308,264.00	8,693,236.00	79.30
Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,137,000.00	8,338,653.00	1,798,347.00	82.26
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,488,800.00	57,953,013.54	10,535,786.46	84.62
Газрын төлбөр	22,029,800.00	14,537,351.00	7,492,449.00	65.99
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,323,900.00	4,534,685.58	1,789,214.42	71.71
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	279,024,000.00	235,371,552.00	43,652,448.00	84.36
Бараа үйлчилгээний бусад зардал	13,037,317,400.00	11,911,978,922.42	1,125,338,477.58	91.37
Бараа үйлчилгээний бусад зардал	979,327,300.00	817,166,253.94	162,161,046.06	83.44
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,057,990,100.00	11,094,812,668.48	963,177,431.52	92.01
ТАТААС	570,729,425,700.00	570,729,425,700.00	0.00	100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	570,729,425,700.00	570,729,425,700.00	0.00	100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	570,729,425,700.00	570,729,425,700.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	435,980,641,400.00	412,420,123,240.21	23,560,518,159.79	94.60
Засгийн газрын урсгал шилжүүлэг	64,318,689,400.00	64,274,148,555.73	44,540,844.27	99.93
Засгийн газрын дотоод шилжүүлэг	64,147,073,000.00	64,102,534,225.73	44,538,774.27	99.93
Засгийн газрын гадаад шилжүүлэг	171,616,400.00	171,614,330.00	2,070.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	371,661,952,000.00	348,145,974,684.48	23,515,977,315.52	93.67
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,592,000.00	2,349,000.00	243,000.00	90.63
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	305,626,508,900.00	291,194,633,531.00	14,431,875,369.00	95.28
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	272,734,100.00	270,948,436.00	1,785,664.00	99.35
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,800,000,000.00	52,926,236,082.22	8,873,763,917.78	85.64
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,244,745,400.00	1,141,222,932.00	103,522,468.00	91.68
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,143,566,800.00	1,113,319,500.00	30,247,300.00	97.36
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,571,804,800.00	1,497,265,203.26	74,539,596.74	95.26
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,433,286,200.00	16,085,140,410.46	7,348,145,789.54	68.64
Барилга байгууламж	16,601,725,600.00	12,590,276,114.25	4,011,449,485.75	75.84
Их засвар	2,422,200,000.00	2,074,446,296.00	347,753,704.00	85.64
Тоног төхөөрөмж	4,409,360,600.00	1,420,418,000.21	2,988,942,599.79	32.21
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000,000,000.00	20,000,000,000.00	0.00	100.00
Эргэж төлөгдөх зээл	20,000,000,000.00	20,000,000,000.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,146,885,230,600.00	1,112,256,415,825.41	34,628,814,774.59	96.98
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,060,445,069,400.00	1,042,372,361,580.91	18,072,707,819.09	98.30

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
0.00 100.00
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАТ ДҮГИЙТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Улсын төсвөөс санхүүжих	1,060,445,069,400.00	1,042,372,361,580.91	18,072,707,819.09	98.30
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	527,190,600.00	506,778,183.00	20,412,417.00	96.13
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	527,190,600.00	506,778,183.00	20,412,417.00	96.13
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	74,834,065,000.00	62,257,770,903.25	12,576,294,096.75	83.19
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,281,832,600.00	52,373,313,287.56	10,908,519,312.44	82.76
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,176,180,700.00	2,865,099,162.18	-688,918,462.18	131.66
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,376,051,700.00	7,019,358,453.51	2,356,693,246.49	74.86
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	11,078,905,600.00	7,119,505,158.25	3,959,400,441.75	64.26
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	11,078,905,600.00	7,119,505,158.25	3,959,400,441.75	64.26
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,546,903,691.09	-6,546,903,691.09	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,954,858,725.77	-4,954,858,725.77	0.00
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	53,236.00	43,934.00	9,302.00	82.53
БАЙГУУЛЛАГЫН ТОО	92.00	84.00	8.00	91.30
Төсвийн байгууллага	45.00	45.00	0.00	100.00
Төсвөөс гадуур байгууллага	47.00	39.00	8.00	82.98
АЖИЛЛАГСАДЫН ТОО	5,173.00	5,082.00	91.00	98.24
Удирдах ажилтан	196.00	182.00	14.00	92.86
Гүйцэтгэх ажилтан	3,696.00	3,633.00	63.00	98.30
Үйлчлэх ажилтан	1,264.00	1,247.00	17.00	98.66
Гэрээт ажилтан	17.00	20.00	-3.00	117.65
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	42,798.00	33,686.00	9,112.00	78.71
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	42,798.00	33,686.00	9,112.00	78.71
Төрийн өмчит МСҮТ	26,221.00	23,650.00	2,571.00	90.19
Хувийн МСҮТ	16,577.00	10,036.00	6,541.00	60.54
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5,173.00	5,082.00	91.00	98.24
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,459.00	1,459.00	0.00	100.00
Ажлын албаны албан хаагч (АА)	2.00	2.00	0.00	100.00
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1,878.00	1,859.00	19.00	98.99
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	83.00	83.00	0.00	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,736.00	1,670.00	66.00	96.20
Гэрээт ажилтан	13.00	7.00	6.00	53.85
Улс төрийн албан хаагч (УТ)	2.00	2.00	0.00	100.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ